



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/341

Ховд

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Ховд аймаг дахь “Хөгжил политехник коллеж”-ийн 250 оюутны дотуур байрны засвар өөрчлөлтийн ажлыг “Буянтын боргио” ХХК-ийн гүйцэтгэсэнээр ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

З.Өмиртай - Аймгийн ерөнхий архитектор бөгөөд, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

С.Мөнх-Очир - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх”хөдөлмөр эрхлэх ур чавдарыг дээшлүүлэх төслийн” худалдан авалтын мэргэжилтэн

С.Эрдэнэчимэг - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх”хөдөлмөр эрхлэх ур чавдарыг дээшлүүлэх төслийн” Барилгын зөвлөх

Н.Батжаргал - Аймгийн Хөгжил политехник коллежийн захиргаа аж ахуйн менежер

Н.Золзаяа - Аймгийн Хөгжил политехник коллежийн дотуур байрны багш

Н.Жавзанханд - Аймгийн Хөгжил политехник коллежийн ерөнхий нягтлан бодогч

С.Батдорж - Аймгийн архивын тасгийн дарга


Д.Энхбаяр - "Буянтын боргио" ХХК-ний захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Тогтохбаяр - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. "Хөгжил политехник коллеж"-ийн 250 оюутны дотуур байрны засвар өөрчлөлтийн ажлыг барилгын ажлыг зураг, төслийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг комиссын дарга /З.Өмиртай/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ